



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/246

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/246 тоот захирамж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг бууруулах, сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд цахимаар ажиллах 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, ажлын байранд ирж ажиллах нийт ажилтнуудын 30% буюу 19 албан хаагчдын нэрс, ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар, ажлын байрнаас компьютер авч гарсан, үргэлжлүүлэн цахимаар ажиллах бусад албан хаагчдын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цахимаар ажиллах ажилтнуудыг үүрэгжүүлж, ажлын гүйцэтгэл болон ирцэнд өдөр бүр хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг хэлтсийн дарга нарт (Л.Эрдэнэбат, Л.Ганбат, Э.Энхбаяр, Ш.Энхжаргал, Г.Уранбайгал, В.Мөнхжаргал, Б.Гүнжидмаа) даалгасугай.

3. Ажлын байранд ирж ажиллах ажилтнуудын ирц, ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллахыг захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

4. Хариуцсан хэлтсүүдийн төлөвлөгөөт ажлыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан чанартай гүйцэтгүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Судалгаа хариуцсан орлогч дарга (С.Очир-Эрдэнэ), Ерөнхий инженер (Ж.Баясгалан) нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА